



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, нийт 45,833,000.00 /дөчин таван сая найман зуун гучин гурван мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга М.Энх-Амар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Акталж, данснаас хассан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



9008

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн
376. дугаар тогтоолын хавсралт



Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын
Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуриатлагдсан элэгдэл (төгрөг)
1	Ниссан теана, 47-08 УНМ, арал № JN1BAUJ32Z0000136	2008/ 2008	45,833,000.00
	Нийт дүн		45,833,000.00 /дөчин таван сая найман зуун гучин гурван мянган/